| 210102                | Нэмэгдэл  | 25,815,300.00         | 22,366,874.00  | 3,448,426.00 | 86.6  |
| 210103                | Унаа хоолны хөнгөлөлт                                 | 7,177,100.00          | 7,084,500.00   | 92,600.00    | 98.7  |
| 2102                  | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b> | 22,778,400.00         | 22,221,534.00  | 556,866.00   | 97.6  |
| 210201                | Тэтгэврийн даатгал                                    | 16,220,000.00         | 15,740,253.44  | 479,746.56   | 97.0  |
| 210202                | Тэтгэмжийн даатгал                                    | 1,752,100.00          | 1,721,120.14   | 30,979.86    | 98.2  |
| 210203                | ҮОМШӨ-ний даатгал                                     | 1,281,700.00          | 1,269,375.88   | 12,324.12    | 99.0  |
| 210204                | Ажилгүйдлийн даатгал                                  | 320,400.00            | 317,344.26     | 3,055.74     | 99.0  |
| 210205                | Эрүүл мэндийн даатгал                                 | 3,204,200.00          | 3,173,440.28   | 30,759.72    | 99.0  |
| 2103                  | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>      | 40,351,600.00         | 40,202,851.82  | 148,748.18   | 99.6  |
| 210301                | Гэрэл, цахилгаан                                      | 1,402,400.00          | 1,146,629.11   | 255,770.89   | 81.8  |
| 210302                | Түлш, халаалт   | 38,325,100.00         | 37,817,268.71  | 507,831.29   | 98.7  |
| 210303                | Цэвэр, бохир ус                                       | 624,100.00            | 1,238,954.00   | -614,854.00  | 198.5 |
| 2104                  | <b>Хангамж, бараа материалын зардал</b>               | 7,848,600.00          | 7,847,924.20   | 675.80       | 100.0 |
| 210401                | Бичиг хэрэг   | 2,121,600.00          | 1,195,600.00   | 926,000.00   | 56.4  |
| 210402                | Тээвэр, шатахуун                                      | 312,100.00            | 312,000.00     | 100.00       | 100.0 |
| 210403                | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                    | 1,050,000.00          | 1,336,724.20   | -286,724.20  | 127.3 |
| 210404                | Ном, хэвлэл   | 3,564,900.00          | 4,203,600.00   | -638,700.00  | 117.9 |
| 2105                  | <b>Нормативт зардал</b>                               | 390,300.00            | 390,000.00     | 300.00       | 99.9  |
| 210503                | Нормын хувцас, зөөлөн эдлэл                           | 390,300.00            | 390,000.00     | 300.00       | 99.9  |
| 2106                  | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>              | 3,843,000.00          | 3,822,990.00   | 20,010.00    | 99.5  |
| 210604                | Урсгал засвар   | 3,593,000.00          | 3,572,990.00   | 20,010.00    | 99.4  |
| 2108                  | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний</b>       | 3,403,600.00          | 3,097,150.00   | 306,450.00   | 91.0  |

|             |  |                |                |              |      |
|-------------|--|----------------|----------------|--------------|------|
|             | <b>төлбөр, хураамж</b>                   |                |                |              |      |
| 210803      | Даатгалын үйлчилгээ                      | 145,000.00     | 119,250.00     | 25,750.00    | 82.2 |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар               | 47,500.00      | 42,000.00      | 5,500.00     | 88.4 |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ          | 2,106,200.00   | 1,831,000.00   | 275,200.00   | 86.9 |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>   | 4966700.00     | 4891700.00     | 75,000.00    | 98.5 |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх        | 4,966,700.00   | 4,891,700.00   | 75,000.00    | 98.5 |
|             | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>    | 258,876,500.00 | 254,198,595.02 | 4,677,904.98 | 98.2 |
| <b>1310</b> | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>           | 258,876,500.00 | 253,746,795.02 | 5,129,704.98 | 98.0 |
| 131007      | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 258,876,500.00 | 253,746,795.02 | 5,129,704.98 | 98.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код  | Үзүүлэлт   | Гүйцэтгэл           |
|-------------|--|---------------------|
|             | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>  |                     |
| <b>I</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>   | <b>4,809,228.20</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>4,809,228.20</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   | 4,809,228.20        |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>  | 4,316,228.20        |
| 210401      | Бичиг хэрэг  | 2,280,790.00        |
| 210402      | Тээвэр, шатахуун   | 2,035,438.20        |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>  | 250,000.00          |
| 210503      | Нормын хувцас, зөөлөн эдлэл  | 250,000.00          |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>   | 243,000.00          |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл  | 243,000.00          |
| <b>II</b>   | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>  | 4809228.20          |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | 4,809,228.20        |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,250,000.00        |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                               | 3,559,228.20        |

### **3. Аудитын тайлан**

---

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нийтийн номын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Нийтийн номын санд Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал, хууль журам хэрэгжүүлж ажиллахтай холбоотой асуудлаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ньюбаланс аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Гэрэлчулуун, аудиторын туслах С.Гэрэлдаваа нар гүйцэтгэж, хяналтыг Ньюбаланс аудит ХХК-ийн аудитын менежер Б.Лхагвадорж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийтийн номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ньюбаланс аудит ХХК –д 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 20 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Нийтийн номын сан нь “Оюуны бүтээлийг цуглуулан баяжуулж, хадгалан хамгаалж нээлттэй хүртээмжтэй мэдлэг мэдээллээр нийтэд үйлчлэх, түгээх хойч үедээ өвлүүлэн үлдээх” зорилго дэвшүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс

үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийтийн номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл /бага/ гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлан нийт зардлын 297.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 5.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Нийтийн номын сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 55.7 сая төгрөгөөр буюу 4.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт                                   | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт    |
|--|----------------|-----------------|-------------|
| Б  | 1              | 2               | 3=2-1       |
| Авлага                                     |                | 2.2             | 2.2         |
| Бараа материал                             | 8.0            | 8.5             | 0.5         |
| Биет хөрөнгө                               | 1,215.6        | 1,266.6         | 51.0        |
| Биет бус хөрөнгө                           | 110.0          | 112.1           | 2.0         |
| <b>Нийт хөрөнгө</b>                        | <b>1,333.7</b> | <b>1,389.4</b>  | <b>55.7</b> |
| Өглөг                                      |                | 0.009           | 0.009       |
| Хуримтлагдсан үр дүн                       | -171.3         | -115.6          | 55.7        |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 1,333.7        | 1,389.4         | 55.7        |

Бараа материалын дансны үлдэгдэл 8.5 сая төгрөг болж 0.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд Бичиг хэргийн материал, Бусад хангамжийн материал дансанд хөрөнгө авсан үлдэгдэл өсөхөд нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,378.7 сая төгрөг болж 53.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд Аймгийн ИТХ ын 2021 оны 12 дугаар сарын 20 ны өдрийн 111 тоот тогтоолоор элэгдлээрээ анхны өртөгөө нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгөнд дахин үнэлгээ хийх шийдвэрийн дагуу 78.7 сая төгрөгийн дахин үнэлсэн хөрөнгө орлого авч, 91.3 сая төгрөгийн элэгдлээрээ анхны өртөгөө нөхсөн хөрөнгө хасагдаж

мөн тайлант онд төсвийн хөрөнгөөр 2.9 сая төгрөгийн ном авч, хандиваар 10.7 сая төгрөгийн хөрөнгө орлого авч, 39.3 сая төгрөгийн элэгдэл байгуулсан дүн нөлөөлжээ.

Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй нягтлан бодох бүртгэлийн программ 2009 онд, номын программ 2012 онд тус тус ашиглалтанд орж 5 жилээр элэгдүүлэн анхны өртөгөө нөхсөн тул нягтлан бодох бүртгэлийн программыг 0.8 сая төгрөг, номын программыг 1.2 сая төгрөг нийт 2.0 сая төгрөгөөр дахин үнэлэж бүртгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,387.9 сая төгрөг болж 55.7 сая төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй ирсэн хөрөнгө, дахин үнэлсэн хөрөнгийн орлого, хасагдсан хөрөнгийн дүн зэрэг нөлөөлжээ.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан Улсын төсвийн санхүүжилт 8.1 сая төгрөгөөр буурч, үнэ төлбөргүй орлого 89.9 сая төгрөгөөр өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 0.4 сая төгрөгөөр буюу 0,2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалингийн зардал, тогтмол зардал, урсгал засварын зардлууд 6.8 сая төгрөгөөр буурч, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, хангамжийн материалын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, элэгдлийн зардлууд 6.4 сая төгрөгөөр өсчээ.

Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны дүнд 2.4 сая төгрөгийн залруулга хийгдсэн дүнгээр нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр хуримтлагдсан үр дүнд өөрчлөлт орсон байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Нийтийн номын сангийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 252.8 сая төгрөгөөр, нийт зарлагыг 252.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийг 252.8 сая төгрөгөөр баталсан байна.

Энэ төсвийн жилд батлагдсан төсөвт Аймгийн засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 07 ны өдрийн А/608 тоот захирамжаар 1 удаа тодотгол хийж цалингийн зардлаас 1.1 сая төгрөг, гэрэл цахилгааны зардлаас 0.7 сая төгрөг, цэвэр бохир усны зардлаас 1.9 сая төгрөг, нийт 3.7 сая төгрөгийг хасаж, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 1.1 сая төгрөг, хичээл үйлдвэрлэлийн зардалд 2.0 сая төгрөг, Бичиг хэргийн зардалд 1.4 сая төгрөг, Ном хэвлэлийн зардалд 1.5 сая төгрөг, БҮТЭЗ-ийн зардалд 0.3 сая төгрөг, Урсгал засварын зардалд 3.1 сая төгрөг, газрын төлбөрт 0.1 сая төгрөг нийт 9.7 сая төгрөгийг нэмж тодотгосон байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Нийтийн номын сангийн тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 258.8 сая төгрөгийн төсөв баталснаас 258.8 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 258.8 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 254.1 сая төгрөгийг зарцуулж улсын төсвийн санхүүжилтээс 4.6 сая төгрөг, өөрийн орлогоос 0.4 сая төгрөг нийт 5.1 сая төгрөг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 254.1 сая төгрөг буюу 98.2 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 4.1 сая төгрөг, бусдаар үйлчлүүлсэн зардал 0.3 сая төгрөг, тогтмол зардлыг 0.1 сая төгрөг, Бараа үйлчилгээний бусад зардлыг 0.1 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээнд 4.6 сая төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

71702 буюу Соёл урлаг хөтөлбөрийн хүрээнд 2 зориулалт арга хэмжээнд зарцуулсан гүйцэтгэлийг хүснэгтээр үзүүлбэл :

Хүснэгт 2: Төсвийн хөтөлбөр, арга хэмжээ /сая төгрөг/

| Зориулалт, арга хэмжээний код | Арга хэмжээний нэр                    | Төсөв        | Гүйцэтгэл    | зөрүү      | Тайлбар      |
|-------------------------------|---------------------------------------|--------------|--------------|------------|--------------|
| 80101                         | Үндсэн үйл ажиллагааны зардал         | 243.0        | 238.4        | 4.6        | төвлөрүүлсэн |
| 80802                         | Ажил олгогчоос олгох тэтгэвэр тэтгэмж | 15.8         | 15.8         |            |              |
| Дүн                           |                                       | <b>258.8</b> | <b>254.1</b> | <b>4.6</b> |              |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нийтийн номын сангийн нэмэлт санхүүжилтийн дансаар тайлант онд Волвес ХХК наас 3.1 сая төгрөг номын сангийн программ нэвтрүүлэх зориулалтаар, Соёлын сайдын А/150 тоот тушаалаар 1.2 сая төгрөг Үндэсний тогтмол хэвлэлийн нэгдсэн лавлагаа мэдээлэлийн цахим сан бий болгоход шаардагдах зардал санхүүжүүлэхээр, Номын сангийн 75 жилийн ойн баяраар гарсан “Хоймор нутгийн номын өргөө “ нэртэй ном борлуулсны үнэ 0.3 сая төгрөг нийт 4.8 сая төгрөг орсон байна.

Нэмэлтээр ирсэн санхүүжилтийн 4.8 сая төгрөгийг төрийн санд хүсэлт өгч зарцуулах эрх авч шатахууны зардалд 2.0 сая төгрөг, бичиг хэргийн зардалд 2.2 сая төгрөг, нормын хувцас болон барааны үнэ 0.4 сая төгрөг шилжүүлэн бараа материал дансанд орлого авч зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Аймгийн Засаг даргын 2021 оны 12 сарын 07-ны өдрийн А/608 тоот захирамжаар төсвийн зохицуулалт хийж нийт 3.7 сая төгрөгийг хасаж, 9.7 сая төгрөгийг нэмж тодотгосон дүнгээс оны эцэст 4.6 сая төгрөгийг хэмнэж төсөвт төвлөрүүлэн Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж ажилласан байна. 2019 онд үүссэн 2.4 сая төгрөгийн өр барагдуулах болон номын санчдын зөвлөгөөний зардалд зориулан ажлын зайлшгүй шаардлагаар нэмж батлуулсан төсөвөө зарцуулж үлдэгдлийг төвлөрүүлжээ.

### **3.8 Аудитын гол асуудал**

Нийтийн номын санд 2021 онд 3 нягтлан бодогч солигдон ажиллажээ. Жилийн санхүүгийн тайлан гаргасан нягтлан бодогч Д.Энхсайхан нь 2021 онд Хөдөө аж ахуйн их сургуулийг нягтлан бодогч мэргэжлээр төгссөн нийтийн номын сангийн захирлын 2021 оны 9 сарын 29-ны Б/60 тоот тушаалаар нягтлан бодогчоор 2021 оны 10 сарын 01-нээс томилогдсон байна. Ажил аваад 10,11,12 сарын ажил гүйлгээг хийхдээ санхүүгийн программтай ажиллах туршлага, дадлага дутснаас нягтлан бодох бүртгэл хөтлөхдөө алдаатай илэрхийлсэн ажил гүйлгээ олон байлаа.

Д.Энхсайханыг нийтийн номын сангийн дотоод журамд заасны дагуу байгууллагаас томилогдсон комисс шалгаруулалт явуулан 2 хүнээс шалгалт авч өндөр оноотой Д.Энхсайханг томилсон нь Сангийн сайдын 294 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхий ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага шалгуур” журмын 2.1 дугаар зүйлийн 2.1.5 заалт, 3.1 дүгээр зүйлийн 3.1.5 заалтуудыг хангаагүй байна

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Төсвийн шууд захирагч нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-д зааснаар, хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай. Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудас болох [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) -д ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгасан. Хөвсгөл аймгийн Нийтийн номын сан нь тайлант хугацаанд оруулбал зохих 10 төрлийн 65 мэдээлэлээс хугацаандаа оруулсан 64 мэдээлэл, хугацаа болоогүй 1 мэдээлэл байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг дахин хянахад Нийтийн номын сангийн 2020 оны санхүүгийн тайлан түүвэрт хамрагдаж бие даасан дүгнэлт өгөөгүй удирдлагын захидал хүргүүлсэн байна. Уг захидалд Аймгийн санхүүгийн хяналт, аудитын албанаас 2020 оны 12 сард тогтоосон зөрчлийн акт, албан шаардлага зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна гэж дүгнэсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Тайлант онд Аймгийн засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 07 ны өдрийн А/608 тоот захирамжаар зарцуулагдаагүй төсвийн 3.7 сая төгрөгийг хасаж 9.7 сая төгрөгийг шаардлагатай зардалд нэмж баталж өгдөг асуудлыг дээд шатандаа анхаарал хандуулах нь зүйтэй .

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 27.7 сая төгрөгийн алдаа ,зөрчил илэрснээс, 26.6 сая төгрөгийн алдааг залруулж, 1.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

### **4.1 Залруулсан алдаа**

#### **Мөнгөн хөрөнгө**

- Харилцах данснаас 6.5 сая төгрөгийн гүйлгээг шууд зардлын дансанд бичиж Сангийн сайдын 388 тоот тушаалаар батлагдсан журмын 2.2 заалт зөрчсөнийг залруулсан.
- Нэмэлт санхүүжилтийн дансанд 75 жилийн ойд зориулан гаргасан ном борлуулсны үнэ 0.4 сая төгрөгийг давхар орлого авч мөнгөн хөрөнгийн үлдэгдэл буруу илэрхийлсэн тул залруулав.

#### **Бараа материал**

- Бараа материал дансны үлдэгдэлд Талархал, Сувинер гэсэн 0.7 сая төгрөгийн барааг номын санчдын зөвлөлгөөнд оролцсон хүмүүст зарцуулсан боловч зарлага гаргаагүй санхүүгийн тайлан буруу илэрхийлсэн тул зарлагаар зөвшөөрч залруулав.

#### **Үндсэн хөрөнгө**

- Элэгдлээрээ анхны өртөгөө нөхсөн боловч одоо ашиглагдаж байгаа хөрөнгөнд дахин үнэлгээ хийж үнэ тогтоох тухай Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 20 - ны өдрийн 111 тоот тогтоолын дагуу дахин үнэлгээ хийж элэгдлээрээ анхны өртөгөө нөхсөн 26.8 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасч, дахин үнэлэгдсэн 19.6 сая төгрөгийн хөрөнгийг орлогоор бүртгээгүй алдааг залруулсан.
- Барилга, тоног төхөөрөмж, тавилга зэрэг хөрөнгийн 10.11.12 сарын элэгдэл санхүүгийн программд татагдаагүй, мөн газар хөрөнгөнд 0.3 сая төгрөгийн элэгдэл тооцож санхүүгийн тайлан буруу илэрхийлсэн алдааг залруулав.
- 2018 онд ашиглалтанд орсон 0.8 сая төгрөгийн үнэ бүхий элэгдэл дуусаагүй, зөөврийн компьютер хөрөнгийг актлах шийдвэргүй данснаас хасч 0.2 сая төгрөгийн гарз зөвшөөрсөн алдааг залруулсан.

### **Зардал**

- Тайлант онд өмнө оны өглөг төлсөн 2.4 сая төгрөгийг тайлант оны зардлаар зөвшөөрсөн алдааг өмнө оны үр дүн дансанд залруулсан.
- Ч.Цэнгэлд шүүхийн шийдвэрээр олгосон ажиллаагүй хугацааны цалин 2.2 сая төгрөгийг авлага үүсгэж залруулав.

#### 4.2 Төлбөрийн акт

Нийтийн номын сангийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

#### 4.3 Албан шаардлага

Нийтийн номын сангийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгөөгүй болно.

#### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал**

#### 1.1. Илрүүлэлт:

1.2. Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27–ний өдрийн “Журам батлах тухай” 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтлөөгүйгээс шалтгаалан 26.6 сая төгрөгийн алдаа илэрсэн.

#### 1.3. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн “Журам батлах тухай” 294 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам” –ын 2 дугаар зүйлийн 2.1.5-д “Шууд захирагч нарын ахлах нягтлан бодогч нь нягтлан бодогчоор 2-оос доошгүй жил ажилласан, бие даан санхүүгийн тайлан гаргах чадвартай байх.” гэсэн шаардлага, шалгуурыг бүрэн хангаагүй байх тул шинээр томилогдсон нягтлан бодогчийг Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27–ний өдрийн “Журам батлах тухай” 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу алдаа зөрчилгүй ажиллуулах.

### **2. Хууль журам хэрэгжүүлж ажиллахтай холбоотой асуудал**

#### 2.1 Илрүүлэлт:

Тайлант онд өөрийн орлогоор орсон 1.1 сая төгрөгийг кассаар зарцуулж Сангийн сайдын 276 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын үйл ажиллагааны журам” зөрчсөн байна.

#### 2.2 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 276 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам” хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн |      | Үүнээс    |      |               |     |                 |     |         |     |
|-----|-------------------------------------|----------------------|------|-----------|------|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
|     |                                     |                      |      | Залруулга |      | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     |
|     |                                     | Тоо                  | Дүн  | Тоо       | Дүн  | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн |
|     | Нийтийн номын сан                   | 9                    | 27.7 | 8         | 26.6 |               |     |                 |     | 1       | 1.1 |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРААС  
ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

АХЛАХ АУДИТОР

НЬЮБАЛАНС АУДИТ ХХК-ИАС  
ХЯНАСАН:

ЗАХИРАЛ

БОЛОВСРУУЛСАН:  
АХЛАХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

Огноо:

Э.БАТ-ЭРДЭНЭ

Огноо:

Г.ЭРДЭНЭЧИМЭГ

Огноо:

Б.ЛХАГВАДОРЖ

Огноо: 2022.02.22

Д.ГЭРЭЛЧУЛУУН

Огноо: 2022.02.22